

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2. Төслийн хүчин чадал, агуулахын төлөвлөлт.....	5
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
2.1. Физик газарзүй, ландшафт.....	7
2.2. Газрын гадарга, геоморфологи.....	7
2.3. Цаг уур, уур амьсгалын төлөв байдал.....	8
2.3.1. Агаарын температур.....	8
2.3.2. Салхины горим	11
2.4. Гадаргын болон газрын доорх усан орчин	12
2.4.1. Гадаргын ус.....	12
2.4.2. Газрын доорхи ус	15
2.5. Хөрсөн бүрхэвч	15
2.6. Ургамалан нөмрөг	16
2.7. Амьтны аймаг	18
2.8. Нийгэм, эдийн засгийн төлөв байдал.....	19
2.8.1. Хүн ам	19
2.8.2. Эрүүл мэнд.....	21
2.8.3. Төсөв санхүү	21
2.8.4. Хөдөө аж ахуй	22
2.8.5. Аж үйлдвэр	23
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	24
3.6. Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд болон хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	28
3.7. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, нөлөөллийн үнэлгээний нэгтгэл	28
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН	30
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	30
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024 ОН)...	32
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН).....	34
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2024 ОН)	35
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2024ОН).....	36
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	40
АРВАННЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	43
АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024 ОН).....	44

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг /Google earth/	4
Зураг 2. Гаалийн хяналтын талбайн төлөвлөлт	5
Зураг 3. Ландшафтын бүс, мужлалтын зураг	7
Зураг 4. Монгол орны геоморфологийн зураг	8
Зураг 5. Сарын дундаж агаарын температурын явц.....	9
Зураг 6. Жилийн дундаж агаарын температурын явц.....	9
Зураг 7. Жилийн нийлбэр дундаж хур тунадас	10
Зураг 8. Сарын нийлбэр дундаж хур тунадас	11
Зураг 9. Салхины үнэмлэхүй их хурд	11
Зураг 10. Салхины үнэмлэхүй их хурд	12
Зураг 11. Салхины чиглэл /2017-2023/.....	12
Зураг 12. Монгол орны гол мөрний ай сав (а) ба голын сүлжээний нягтшил (b)	13
Зураг13. Гидрогеологийн мужлал	13
Зураг 14. Зуны хур бороо (а) болон хаврын шар усны (b) үерийн хамгийн их урсац, мм	14
Зураг 15. Монгол орны усны кальцийн ионы агууламжийн тархац, мг/л	15
Зураг 16. Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын зураг	16
Зураг 17. Ханбогд сумын ургамалжил.....	16
Зураг18. Бэлчээрийн төрх байдал	17
Зураг 19. Ургамлын амьдралын хэлбэр	17
Зураг 20. Нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамал	18
Зураг 21. Ханбогд суманд бүртгэсэн хамгаалалтанд авах шаардлагатай зүйлийн бүрдлийн бүтэц	18
Зураг 22. Говийн амьтад.....	19
Зураг 23. Хүн амын тоо (Ханбогд сум).....	20
Зураг 24. Өрхийн тоо (Ханбогд сум)	20
Зураг 25. Насны бүлэг (Ханбогд сум).....	21
Зураг 26. Төрөлт, нас баралтын тоо	21
Зураг 27. Малчин өрх, малын тоо толгой (Ханбогд сум).....	23
Зураг 28. Ханбогд сумын малын тоо толгой, багаар.....	23
Зураг 29. Орчны нөлөөллийн бүс.....	24
Зураг 30. Гаалийн хяналтын талбайгаас үүсэх тоосонцорын хэвтээ орон зайн тархалт	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Төслийн талбайн солбилцол	4
Хүснэгт 2.Агаарын температурын үзүүлэлт.....	9
Хүснэгт 3. Хур тунадасны үзүүлэлт /сараар/.....	10
Хүснэгт 4. Хур тунадасны үзүүлэлт /жилээр/	10
Хүснэгт 5. Салхины үнэмлэхүй их хурд.....	11
Хүснэгт 6.Салхины үзүүлэлт	11
Хүснэгт 7. Хоногт орсон 1 хувийн хангамшил бүхий хур бороо.....	14
Хүснэгт 8. Усны хатуулаг чанарын ангилал	14
Хүснэгт 9. Малын тоо толгой, малчин өрх (Ханбогд сум)	22
Хүснэгт 10. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ.....	26
Хүснэгт 11. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ.....	26
Хүснэгт 12. Усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ.....	26
Хүснэгт 13. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ	27
Хүснэгт 14. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ	27
Хүснэгт 15. Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ.....	28
Хүснэгт 16. Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх болзошгүй нөлөөллийн үнэлгээний нэгтгэл.....	28
Хүснэгт 17. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	32
Хүснэгт 18.Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	34
Хүснэгт 19. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	35
Хүснэгт 20. Аюултай хог хаягдлын ангилалын жагсаалт	36
Хүснэгт 21. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	39
Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	41
Хүснэгт 23. Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт.....	43
Хүснэгт 24. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах хуваарь.....	44
Хүснэгт 25.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн	45

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Гаалийн хяналтын талбай байгуулах”

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “МЧТ” ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9011772016, Регистрийн дугаар: 6359183)

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, 40, 50 мянгат, ЭТӨЧ, 54, 1405 тоот холбоо барих утас: 99100612

Төслийн зорилго:

Төслийн талбайн байршил: Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийн зүүн урд хэсэгт хилээс хойш 20 орчим км-т оршино. Аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 250 км, Ханбогд сумын төвөөс зүүн урагш 70 км зайд 10 га талбайг хамран байрлана.

Хүснэгт 1.Төслийн талбайн солбилцол

Д/д	Градус	Мин	Сек	Градус	Мин	Сек
1	107	29	32.75	42	36	12.61
2	107	29	24.98	42	36	21.07
3	107	29	36.64	42	36	26.67
4	107	29	44.40	42	36	18.21

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг /Google earth/




1.2. Төслийн хүчин чадал, агуулахын төлөвлөлт

“МЧТ” ХХК нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хад хэмээх газарт байрлах өөрийн эзэмшлийн 10 га талбайд өдөрт 5000 тн нүүрс ачиж буулгах хүчин чадалтай “Гаалийн хяналтын талбай байгуулах” юм. Төслийн барилга байгууламжууд дараах бүтэцтэй байна. Үүнд:

- ✚ Нүүрсний агуулах
- ✚ Гаалийн хяналтын талбай-150 тонны цахилгаан пүү 2 ширхэг 2 ширхэг ковш
- ✚ Нийтийн бие засах газар
- ✚ Ажилчдын байр конテナр хаус
- ✚ Ариун цэврийн өрөө, дүш
- ✚ Салхинаас хамгаалах хашаа-8 метрийн өндөртэй

Зураг 2. Гаалийн хяналтын талбайн төлөвлөлт



1.3. Төслийн тоног төхөөрөмж

Тухайн төслийг хэрэгжүүлэхэд доор дурьдсан машин механизм, техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглана. Үүнд :

Төслийн барилгажилтын явцад:

- Экскаватор,
- Ачааны автомашин,
- Дизель станц,
- Автокран,
- Замын индүү,
- Гагнуурын аппарат зэрэг болно.

Объект ашиглалтанд орсоны дараа дор дурьдсан машин механизм, техник тоног төхөөрөмжүүдийг ашиглана.

- ✓ Нүүрс ачиж буулгах цэгт 2м³-ын шанагатай авто ачигч 2 ширхэг
- ✓ 70 болон 100 тоннын даацтай 10 Howo маркийн автосамосвалл
- ✓ Бага оворын трактор нэг тус тус байнга ажиллах болно.


ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Физик газарзүй, ландшафт

Ханбогд сум нь Өмнөговь аймгийн нутгийн зүүн урд хэсэгт Даланзадгад хотоос 250 км, Галбын уулын ар бэл дээр Их булаг хэмээх газар байрлах ба энэ нь далайн түвшнээс дээш 1120 м өндөрт оршино.

“Гаалийн хяналтын талбай байгуулах” төслийн орчин нь физик газарзүйн мужлалтаар Говийн их мужийн Дорнод говийн муж, Дорнод говийн хотгорийн тойрогт (МУ-ын Үндэсний атлас, 2009), байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлалаар Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрогт хамаарна.

Зураг 3. Ландшафтын бүс, мужлалтын зураг



Эх үүсвэр: ГЗБГЗЗГ, ГЗБ- мэдээллийн архив

2.2. Газрын гадарга, геоморфологи


Төсөл хэрэгжих орчин нь гадаргуугийн хэлбэр дүрсээрээ Монгол орны геоморфологийн мужлалаар Дундговь-Өмнөговийн мужийн Галба-Өөшийн говийн тойрогт хамаарах ба гарал үүслээрээ тэгширмэл газар, уулс хоорондын ба уулс дундах хотгор дахь элэгдэлийн гаралтай өргөдмөл гадарга болон голын хөндий дэх хурмал хурдаст хотос гадаргуу бөгөөд нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий үлдмэл уулсын цав толгод голын хурдаст тал зонхилно (Зураг 5, МУ-ын Үндэсний Атлас, 2009).

Хүснэгт 2. Агаарын температурын үзүүлэлт

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Агаарын хамгийн их температур/°C/	7.8	15.8	22.6	32.8	36.1	38.7	40.4	38.4	34.1	31.1	21.2	11.6
Агаарын хамгийн бага температур/°C/	-29.7	-25.2	-14.7	-9.6	-3.2	5.8	-0.4	8.9	0.6	-8.6	-24.9	-28
Агаарын дундаж температур/°C/	-10.3	-6.5	3.4	10.6	17.3	23.9	25.6	22.9	18.4	8.1	-1.0	-9.7


Жилийн, дулаан ба хүйтэн улирлын дундаж температурын олон жилийн явц болон түүний өөрчлөлтийн хандлагын байдлыг доор зурагт үзүүлэв.

Зураг 5. Сарын дундаж агаарын температурын явц



Агаарын үнэмлэхүй хамгийн их температур +40.4°C хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага температур -29.7°C хүрч хүйтэрсэн байна.

Зураг 6. Жилийн дундаж агаарын температурын явц



2.3.2. Хур тунадас

Өвөлд орох цасны дундаж хэмжээ 10 см-ээс бага, цас тогтох хугацаа 11-р сарын 21-ээс 12 сарын 01, цас арилах хугацаа 3-р сарын 15 хүртэл үргэлжилдэг. Уур амьсгалын дулааралт, хуурайшилтын үйл явц сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц илэрч байна. 2017-2023 онуудад тус аймагт 74.0-201.7 мм тунадас унасан байна. Жилд орох хур тунадасны дийлэнхи хувь нь зуны улиралд буюу 7, 8-р саруудад ордог байна.

Хүснэгт 3. Хур тунадасны үзүүлэлт /сараар/


I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сарын нийлбэр, мм											
6.80	34.00	15.40	16.40	38.70	60.30	336.0	217.2	60.9	32.6	6.2	3.7

Нийлбэр тунадасны хэмжээнд гарч буй өөрчлөлтийг тодорхойлохын тулд жилийн болон дулаан, хүйтэн улирлын тунадасны олон жилийн явцыг гаргаж өөрчлөлтийг нь авч үзлээ. Жилийн нийлбэр хур тунадас 5-н жилийн хугацаанд дундаж 3.7-217.2 мм унасан байна. Хамгийн их нь 2021 онд унасан бол хамгийн бага нь 2017, 2023 онуудад унасан байна.

Хүснэгт 4. Хур тунадасны үзүүлэлт /жилээр/


2017	2018	2019	2020	2021	2022	2023
Жилийн нийлбэр тунадас, мм						
74	188.3	103.6	104	201.6	82.7	74

Зураг 7. Жилийн нийлбэр дундаж хур тунадас



Хур тунадасны сарын хуваарилалтыг авч үзвэл 7-8-р сард хур тунадасны ихэнх унадаг бол 12-1-р сард хур тунадас хамгийн бага унадаг байна.

Зураг 8.Сарын нийлбэр дундаж хур тунадас




2.3.3. Салхины горим

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газар зүйн нөхцлөөс шалтгаална. Говь хээрийн бүсэд хамаарагдах ба нөмөрлөж хаах уул, нуруу ховор учраас салхитай нутагт хамаарагдана. Салхины зонхилох чиглэл баруун ба баруун хойд талаасаа байдаг. 2-6 м/с хурдтай салхины давтамж 60-аад хувь байна. Хавар цагт салхины хамгийн дээд хурд 30 м/с хүрдэг байна. Энэ үед шороогоор шуурах нь элбэг. 15 м/с-ээс илүү хурдтай хүчтэй салхилдаг хоногийн тоо жилд 20-30 өдөр, явган шуургатай өдөр 10 орчим, хүчтэй цасан шуургатай өдрийн тоо 10 гаруй байдаг.

Хүснэгт 5. Салхины үнэмлэхүй их хурд

Сар Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Салхины дундаж хурд, м/с	24	24	23	23	26	28	22	23	24	24	18	17


Зураг 9.Салхины үнэмлэхүй их хурд



Хүснэгт 6.Салхины үзүүлэлт


Сар Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Их хурд, м/с	26	24	25	22	28	23	27

Зураг 10. Салхины үнэмлэхүй их хурд



Дээрх хүснэгтээс үзэхэд тухайн бүс нутагт баруун хойд болон баруун зүгийн салхи зонхилдог болох нь харагдаж байна.

Зураг 11. Салхины чиглэл /2017-2023/




2.4. Гадаргын болон газрын доорх усан орчин

2.4.1. Гадаргын ус

“Гаалийн хяналтын талбай” орчимд түр зуурын урсгалтай гол горхи, тогтмол гадаргын усан сан байхгүй.

Монгол орны өмнөд хэсэг болох говь, цөл нь гадаргын усны ангиллаар, Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтах /Зураг 17 (a)/ ба энд гол мөрний сүлжээний нягтшил 0,01 буюу түүнээс бага /Зураг 17 (b)/, хаврын шар ус, зуны хур борооны үед гадаргын түр урсац үүсгэх хуурай сайр, жалга бүхий бүс нутаг юм.


Зураг 12. Монгол орны гол мөрний ай сав (a) ба голын сүлжээний нягтшил (b)



a) 1-Хойд мөсөн далайн ай сав, 2-Номхон далайн ай сав, 3-Төв Азийн гадагш урсацгүй ай сав

Газрын доорхи усны тэжээлийн ангиллаар улирлын хомс тэжээл бүхий мужид багтана (Зураг 13).


Зураг 13. Гидрогеологийн мужлал



1. Түр зуурын элбэг тэжээлтэй, 2. Улирлын дунд зэргийн тэжээлтэй, 3. Улирлын хомс тэжээлтэй

Гадаргын урсац бүрдэх хэмжээ 0.01 л/с км² буюу түүнээс бага (Зураг 19). Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас байгалийн гамшигт үзэгдлийн тоо, давтамж, тэдгээрийн үргэлжлэх хугацаа, эрчимшил ихээхэн өөрчлөгдөж байгаа ба энэ байдал, манай оронд, хур борооны үргэлжлэх хугацаа богиносч, эрчимшил нэмэгдэх байдлаар илэрч байна. Монгол оронд, үерийн аюул үүсгэх хэмжээний борооны эрчимшил хоногт 40-120 мм байдаг. Говь, цөлийн бүсэд хур тунадас бага хэмжээтэй ордог ч маш аюултай уруйн үер үүсгэх хэмжээний бороо орж байсныг цаг уурын ажиглалтын мэдээнээс харж болно /Хүснэгт 7/.

Зураг 14. Зуны хур бороо (а) болон хаврын шар усны (б) үерийн хамгийн их урсац, мм



Хүснэгт 7. Хоногт орсон 1 хувийн хангамшил бүхий хур бороо

Д/д	Аймаг	Сум-өртөө	Ажиглалтын хугацаа	Ажигласан жилийн		
				Хамгийн их	Хамгийн бага	Дундаж
1	Өмнөговь	Ханбогд	1978-1990	42.7	7.0	21.1
2		Цогт-Овоо	1963-1990	42.0	7.7	17.0
3		Даланзадгад	1940-1989	138.0	7.4	25.7

Говь нутгийн газрын гадаргын өндөршлийн ялгаа төдийлөн их биш ч, өргөн хөндий тал ихтэй, хур борооны, ялангуяа үерийн үед их хэмжээний хохирол, сүйтгэл учруулж чадахуйц (усыг бодвол нягт ихтэй, эвдэх, сүйтгэх хүчин чадал өндөртэй) шавар, чулуун холимог бүхий уруйн үер эдгээр тод бус илрэх судаг, сайраар урсан ирэх магадлал өндөртэй.

Усны чанар


Монгол орны гол мөрний усны химийн найрлага бүрдэх үйл явцад зонхилох үүргийг тухайн сав газрын уулын чулуулаг, хөрс гүйцэтгэх ба говь, хээрийн бүсийн гол горхины ус эрдэсжилт өндөртэй, гидрокарбонат, сульфат, карбонатын ангийн кальци-натрийн, эсвэл натри-кальцийн гэсэн холимог бүлэгт хамаарах ус зонхилох байр суурийг эзэлдэг.

Усны хатуулаг нь, усанд агуулагдах кальци (Ca^{+2}), магни (Mg^{+2}), кальцийн карбонат (CaCO_3) зэрэг эрдэс бодисуудын хэмжээгээр тодорхойлогдох ба $\text{Ca}^{+2} + \text{Mg}^{+2}$ ионуудын нийлбэрээр усны ерөнхий хатуулгийг илэрхийлнэ. Ерөнхий хатуулаг нь, [мг/л] (parts per million /ppm/) болон [мг-экв/л] нэгжээр илэрхийлэгдэнэ /Хүснэгт 8/.

Хүснэгт 8. Усны хатуулаг чанарын ангилал

Д/д	Ангилал	мг-экв/л (Е.В.Посохов, $\text{Ca}^{2+} + \text{Mg}^{2+}$)
1	Маш зөөлөн	... < 1.5
2	Зөөлөн	1.5 – 3.0
3	Боломжийн хатуу	3.0 – 6.0
4	Хатуу	6.0 – 9.0
5	Маш хатуу	9.0 < ...

Зураг 15. Монгол орны усны кальцийн ионы агууламжийн тархац, мг/л



Монгол орны өмнөд хэсэг болох говь цөлийн бүс нутаг нь байнгын урсгал бүхий гол горхи байхгүй, зөвхөн хур тунадастай үед гадаргын түр урсац үүсэх хуурай сайр, жалгуудтай. Нэгэнт гадаргын ус ховор учир, хүн, малын ундны эх үүсвэр нь голын хуурай сайр болон баянбүрд бүхий нутгуудад, газрын өнгөн үе давхаргын усыг ашиглан гаргасан худгууд байдаг. Эдгээр газрууд нь зөвхөн хүн малын ундны усны эх үүсвэр болоод зогсохгүй, тэнд амьдардаг зэрлэг ан амьтдын хоол тэжээлийн бүс, амьдрах, оршин тогтнох цорын ганц орчин нь болж байдаг онцлогтой.


2.4.2. Газрын доорхи ус

Тухайн талбай нь дунд ба эртний төрмөлийн хурдасаас бүрдэх мегаантиклинори түүний бүрэлдэхүүнд багтах өргөргийн сунаж тогтсон Ноёны хотон бүтцийн зэргэлдээ байрлах тул дээрх атираат бүтцүүдийн байрлах гадаргын өндөршлөөс шалтгаалан сэвсгэр хурдас бүхэлдээ хуурайшсан байдаг. Гүний уст үеүд нь хур тунадасны ус болон гольдролуудын дагуух урсацын нэвчилтээр тэжээгдэж байдаг.

2.5. Хөрсөн бүрхэвч

Гаалийн хяналтын талбай байрлах нутаг дэвсгэр нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Говийн мужийн өргөрөгийн бүсшилийн цөлийн бор саарал хөрсний 12-р тойрогт хамрагдана. Энэхүү тойрогт нам уулс, толгодын хэсгээр эх чулуулгын илэрцтэй, дутуу хөгжилтэй сайр чулуурхаг цөлийн бор саарал /гөлтгөнөгүй/, тал хөндий, нам хотос хэсгээр цөлийн бор саарал, цөлийн мараалаг бор саарал, уугуул хэлбэрийн мараа хөрс, элсэн хөрс голлон тархана [БНМАУ-ын Үндэсний Атлас, 1990].

Зураг 16. Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын зураг




Тухайн нутаг дэвсгэрт цөлийн бор саарал хөрсний төрөлд багтах дараах төрлийн хөрс тархана.
Үүнд:

- Эх чулуулгын илэрцтэй цөлийн бор саарал
- Цөлийн бор саарал
- Элсэн хучаастай далд глейрхэг цөлийн бор саарал
- Сайр чулуурхаг нимгэн цөлийн бор саарал
- гэсэн хөрс голлон тархсан байна.

2.6. Ургамалан нөмрөг


Ханбогд сум нь байгаль ургамал газар зүйн тархацын мужлалын хувьд А.А.Юнатовын (1952) ангиллаар Евро-Азийн хээрийн мужийн Умард говийн цөлийн хээрийн провинцийн Дорнод говийн цөлийн хээрийн тойргийн Цогтцэцийн район, Азийн цөлийн мужийн Умард говийн провинцийн: Алашаа говийн цөлийн тойргийн Галбын говийн районуудад хамаарна. Дорнод говийн цөлийн хээрийн тойрог. Ханбогд сумын Галбын говиос баруун ба зүүн хойт чигт үргэлжилсэн уудам хотгор нь Дорноговийн цөлийн хээр юм.

Зураг 17. Ханбогд сумын ургамалжил




Сумын бэлчээрийн ургамалжилтын төрх байдал, доройтол. Сумын нийт нутаг дэвсгэрийн бэлчээрийн төрх байдлын 35.7 хувийг сөөгтэй бэлчээр, 27.3 хувийг чулуутай бэлчээр, 9.3 хувийг заган ойтой бэлчээр тус тус эзэлж байна.

Зураг 18. Бэлчээрийн төрх байдал



Ургамлын амьдралын хэлбэр. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа 161 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 34 зүйл нэг ба хоёр наст өвслөг ургамал (21.1%), 75 зүйл олон наст өвслөг ургамал (46.6%), 45 зүйл сөөг, сөөгөнцөр ургамал (27.9%), 4 зүйл шарилж шимэгч ургамал (2.5%), 3 зүйл модлог ургамал (1.9%) бүртгэгдсэн байна.


Зураг 19. Ургамлын амьдралын хэлбэр



Ургамлын ач холбогдол ба хор холбогдол. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт ургаж байгаа бүх зүйл ургамлаас 25 овог, 87 төрлийн 127 зүйл бэлчээр тэжээлийн ач холбогдолтой ургамал (78.9%), 21 овог, 35 төрөл, 46 зүйлийн (28.6%), 10 овог, 24 төрлийн 34 зүйл (21.1%) ургаж байна.

Ханбогд сумын нутагт ургаж байгаа 11 зүйл нэн ховор, 13 зүйл ховор, 26 зүйл Монголын унаган ургамал (эндемик), 25 зүйл завсарын унаган ургамал, 11 зүйл үлдэц (реликт) ургамал ургаж байна.

Зураг 20. Нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамал



Зураг 21. Ханбогд суманд бүртгэсэн хамгаалалтанд авах шаардлагатай зүйлийн бүрдлийн бүтэц

Ургамал хамгааллын статус	Ангилал зүй			Эзлэххувь
	Овог	Төрөл	Зүйл	
Нэн ховор ургамал	8	12	12	7.5%
Үлдэц ургамал	9	11	11	6.8%
Ховор ургамал	10	12	13	8.1%
Монголын унаган ургамал	10	22	26	16.1%
Монголд байгаа завсрын унаган ургамал	14	19	25	15.5%
Нийт				54.0%

Нэн ховор ургамлын ховордох шалтгаан. Судалгаанаас харахад ган, хэт хуурайшил, уулын үер, цөлжилт, салхи зэрэг байгаль цаг уурын нөлөөнөөс болж байгалийн жамаар нөхөн сэргэж ургах чадваргүй болох болон эмнэлэг, хүнс, түлш, малын бэлчээр, уул уурхайн үйлдвэрлэл зэрэг хүний хэрэглээний хүчин зүйлээс болж тархац нөөц хомсдон жилээс жилд улам ховордсоор улмаар устаж үгүй болох аюулд хүрэх магадлалтай юм.

2.7. Амьтны аймаг

Ханбогд сум түүний орчмын ан амьтад нь монгол орны амьтны газарзүйн хуваарилалт /зоогеографийн мужлал/ аар Уулархаг Азийн доод мужийн Монгол Түвдийн провинц, говийн дэд провинцийн хойд говийн тойрогт багтана. Хойд говийн тойргийн онцлог нь говийн бүсийн бүх нутгийг хамардаг учраас амьтны аймаг нь говийн ба зарим талаараа хээрийн амьтдаас бүрддэг.

Махчин амьтадаас: өмхий хүрэн, хярс, үнэг зонхилдог.

Мэрэгч амьтадаас: Монгол даахай, хөх цомч, урт сүүлт шишүүхэй, туурайтнаас: хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг амьтад тохиолдож байна. Цаг агаарын урин дулаан, өвс ургамлын гарц зэргээс шалтгаалж сүүлийн жилүүдэд цагаан зээр хэсэг бусгаараа нүүдэллэн ирэх болсон байна. Монголын болон олон улсын улаан ном, конвенцэд орсон 5-6 зүйл тохиолдох боловч байнга нутагладаггүй.

Мөлхөгчдөөс:нохой гүрвэл (*Teratoscincus przewalskii*), цоохор хонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*), говийн гүрвэл (*Eremias przewalskii*), могой гүрвэл (*Eremias multiocellata*), нарийн могой (*Coluber spinalis*), рашааны могой (*Elaphe dione*), сум могой (*Psammophis lineolatus*), бамбай хоншоорт могой (*Agkistrodon halys*), тэмээн аалз (*Lycosa singoriensis*) зэрэг амьтад амьдардаг. Эдгээрээс зарим амьтадаас "Улаан ном"-д орсон тэмээн сүүлт могой, нарийн могой болно.

Зураг 22. Говийн амьтад



1. Хулан 2. Говийн чоно 3. Сум могой 4. Говийн гүрвэл

Шавьж

Манай гаригт орчин үед мэдэгдэж буй амьтдын дөрөвний гурваас илүү хувийг шавьж дангаараа эзэлнэ. Хөрс, ус, агаар төдийгүй ургамал амьтны бие эрхтэнд амьдардаг хамгийн их нягтшилтай амьтан бол шавьж юм. Одоогийн байдлаар дэлхийд 1.2 сая гаруй зүйл шавьж илрүүлээд байна. Эрдэмтдийн тооцоолж байгаагаас үзвэл энэ тоо нь манай дэлхийд орших шавжийн зүйлийн бүрэлдэхүүний бодит тооны 75 хувь болох юм. Монгол орон түүний дотроос Өмнөговь аймаг нь шавьжаар нэн баялаг бөгөөд эдгээр нутагт амьдрах шавжийн биологи, экологийн судалгаа нь зөвхөн зүйлийн бүрдлийг тогтоох чиглэлд хийгдэж байна.

2.8. Нийгэм, эдийн засгийн төлөв байдал

Ханбогд сум нь 1924 онд Галба сум нэртэйгээр Хадан хошуу гэх газарт анх үүсгэн байгуулагдсан түүхтэй. Үүнээс хойш олон удаа нүүдэллэж 1941 онд одоогийн Их булаг хэмээх газарт суурьшиж хөгжсөөр 100 жилтэйгээ золгож байна. Өмнөговь аймгийн Ханбогд сум нь хойд талаараа Манлай, баруун талаараа Баян-овоо, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, урд талаараа БНХАУ-тай хиллэдэг.

2.8.1. Хүн ам


Өмнөговь аймаг 2023 оны эцэст урьдчилсан байдлаар 75458 хүн амтай болж, 2022 оны эцсийн хүн амаас 2.2 хувиар буюу 1616 хүнээр өслөө. Нийт хүн амын 50.01 хувь

буюу 37738 эрэгтэйчүүд, 49.99 хувь буюу 37720 эмэгтэйчүүд эзлэж байна. Насны бүтцээр ангилвал 33.2 хувийг 0-14 насны хүүхэд, 59.5 хувийг 15-59 насны, 7.4 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна. Өрхийн тоо 25338 болж өмнөх оноос 1623 өрхөөр буюу 6.8 хувиар өссөн дүнтэй байна.


Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас гаргасан хүн амын тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 23712 өрхийн 73939 хүн амтай: 2021 оноос нийт хүн амын тоо 0.12 хувиар буюу 0.861 мянган хүнээр буурсан байна.

Өмнөговь аймгийн Ханбогд суманд 2022 оны байдлаар 2145 өрхөд 8533 хүн оршин сууж байна. Өмнөх оны дүнтэй харьцуулж үзвэл: 29 өрх, 129 хүнээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг 23.Хүн амын тоо (Ханбогд сум)



Зураг 24.Өрхийн тоо (Ханбогд сум)



2022 оны байдлаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын хүн амын 23 хувийг 0-9 насныхан, 15 хувийг 20-29 насныхан, 22 хувь нь идэр насныхан буюу 30-39 насныхан, эзэлж байгаа бол 60-69 насныхан болон +70 дээш насныхан хамгийн бага хувийг эзэлж байна.

Зураг 25. Насны бүлэг (Ханбогд сум)




2.8.2. Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 133 байгууллага ажиллаж байгаагаас улсын төсвийн эрүүл мэндийн байгууллага 17, өрхийн эмнэлэг 3, цэргийн ангийн 3 эмнэлэг, хувийн эмнэлэг 45, хувийн эмийн сан 47, эргэлтийн эмийн сан 13, эм ханган нийлүүлэх төв 5 тус тус ажиллаж байна.

2023 оны эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээгээр 1400 эх амаржиж, 309 хүн нас барсан нь урьд оны мөн үеэс төрөлт 11.7 хувиар өсч, нас баралт 5.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 26. Төрөлт, нас баралтын тоо



Аймгийн хэмжээнд оны эхний 12 сарын байдлаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл 14 гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 26.3 хувиар буурсан, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1 гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 66.6 хувиар буурсан байна.

2.8.3. Төсөв санхүү

Орон нутгийн төсвийн орлого 2023 оны урьдчисан байдлаар 1022.9 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 1058.3 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөсөн хэмжээнээс 3.5 хувиар буюу 80.2 тэрбум төгрөгөөр давуулан биелсэн. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн дагуу улсын төсөвт 456.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн.

Нийт орлогын 84.4 хувь нь татварын орлого, 15.5 хувь нь татварын бус орлого 0.1 хувь хөрөнгийн орлого тус тус эзэлж байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага санхүүжилтэд 1311.6 тэрбум төгрөгийг төлөвлөж 1110.5 тэрбум төгрөгийг зарцуулж 84.7 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 оны урьдчилсан байдлаар орон нутгийн төсвийн зарлага төлөвлөсөн хэмжээнээс 201.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдахад хөрөнгийн зардал 63.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь нөлөөлсөн.

Татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Цалин хөлс түүнтэй адилтгах орлого 26.0 тэрбум, Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 10.8 тэрбум, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 22.4 тэрбум, үйлдвэр үйлчилгээний усны төлбөр 10.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс илүү төвлөрсөн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага санхүүжилтэд 1311.6 тэрбум төгрөгийг төлөвлөж 1110.5 тэрбум төгрөгийг зарцуулж 84.7 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 оны урьдчилсан байдлаар орон нутгийн төсвийн зарлага төлөвлөсөн хэмжээнээс 201.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдахад хөрөнгийн зардал 63.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь нөлөөлсөн байна.

2.8.4. Хөдөө аж ахуй


2023 онд жилийн эцсийн мал тооллогоор нийт мал 2042001 толгой болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 595.3 мянган толгойгоор буюу 22.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тэмээн сүрэг 157179 толгой, адуун сүрэг 92746 толгой, үхэр сүрэг 27570 толгой, хонин сүрэг 547301 толгой, ямаан сүрэг 1217205 толгой тоологдсон байна.

2023 оны эцэст 6246 малчин өрх байгаа нь өнгөрсөн оноос 5.1 хувиар буюу 338 өрхөөр буурсан байна. Хамгийн олон малтай сумаар Ханхонгор 194670, Манлай 183354, Номгон 181349, Мандал-Овоо 168188, Ханбогд 164176 толгой мал тус тус тоолуулсан байна. Малын таван төрлөөр нь авч үзвэл тэмээгээр Ханбогд сум 33252, адуугаар Манлай сум 13208, үхрээр Ханбогд сум 6186, хониор Манлай сум 67169, ямаагаар Номгон сум 133707 толгойгоор тус тус тэргүүлж байна.

Хүснэгт 9. Малын тоо толгой, малчин өрх (Ханбогд сум)


Баг, хороо	2019	2020	2021	2022	2023
Малын тоо	154.39	137.29	117.26	139.39	116.24
Малчин өрх	390	393	426	431	438

Зураг 27. Малчин өрх, малын тоо толгой (Ханбогд сум)



Ханбогд сумын хэмжээнд 2022 оны байдлаар 116 мянган толгой мал тоолуулсанаас Бор тээг баг хамгийн их буюу 48.8 мянга толгой мал толуулсан байна. Харин хамгийн бага нь замын шанд баг 25.72 мянган толгой мал тоолуулсан байна.

Зураг 28. Ханбогд сумын малын тоо толгой, багаар



2.8.5. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 2023 оны эхний 12 сарын байдлаар 5520.9 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг салбараар авч үзвэл уул уурхайн олборлох үйлдвэр 5479.7 тэрбум төгрөг, хүнсний боловсруулах аж үйлдвэр 32.8 тэрбум төгрөг, цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэр 8.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэсэн байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслөөс агаарын чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

3.1.1. Гаалийн хяналтын талбайн орчим үүсэх хий төлөвт агаар бохирдуулагчид

Гаалийн хяналтын талбай дээр ажиллаж байгаа суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрийн түлшний шаталт, дизель генераторын үйл ажиллагаанаас хий төрлийн агаар бохирдуулагчид үүсдэг. Нэгэнт агаар мандалд дэгдсэн бохирдуулагчид нь хүлээн авагчид мэдрэгдэх хүртлээ физик химийн янз бүрийн хувиралд ордог. Мөн түүнчлэн нүүрсний овоолгод шаталт явагдсан үед CO, CO₂, NO_x, SO_x зэрэг хийнүүд үүсэх боломжтой байдаг.

- Төслийн талбайгаас 100 м зайд шууд нөлөөллийн бүс
- Төслийн талбайгаас 200, 500 м зайд шууд бус нөлөөллийн бүсийг авч үзэв.

Зураг 29. Орчны нөлөөллийн бүс



Уг талбай нь Цагаан хадны гаалийн хяналтын талбайнуудын ойролцоо байх бөгөөд бусад талбайн болон өөрийн ажилчдын кемп зэрэгт нөлөөлж байна.

Гаалийн хяналтын задгай талбайд тархах тоосны хэмжээ:

Цагт: 3,6мг/с

Хоногт: 86,4мг/с (өдөрт 2-3 цаг)

Жилд: 31536мг/с хэмжээний тоос агаарт тархахаар байна.

Зураг 30.Гаалийн хяналтын талбайгаас үүсэх тоосонцорын хэвтээ орон зайн тархалт



Салхины хурдыг 5-9 м/с, чиглэл баруун хойноос, 1 гр/сек/м² байна гэж үзвэл, дээрх загварчлалын бодолтын утга нь 100 метр тутамд гэсэн нөхцөлөөр хийгдсэн бөгөөд эх үүсвэр дээрээ 0,006гр/м³ эх үүсвэрээс 100 метрийн зайд 0.0016 гр/м³ 200 метрийн зайд 0.005 гр/м³, эх үүсвэрээс 900 метрийн зайд MNS 4585:2016 стандартын ЗДХ 500 мкг/м³ хязгаарын хэмжээнд тархаж байна. Хамгийн өндөрт тархах тоосны хэмжээ 100 метр байгаа нь ЗДХ-ээс 36 дахин их байна.

Тээвэрлэлтийн замаас үүсэх тоосжилт. Сайжруулаагүй зам эсвэл замгүй хэсгээр тээврийн хэрэгсэл зорчих үед дугуйн даралтын хүчний үйлчлэлээр гадаргуун материал хэмхэрч нунтгардаг. Тээврийн хэрэгсэл зорчин өнгөрөх үед түүний ард дагалдан үүсдэг агаарын хүчтэй турбулент хөдөлгөөний үйлчлэлээр замын гадаргуун материалын эгэл хэсгүүд хөдөлгөөнд орох эргэлдэж буй дугуйгаар зарим хөрсний эгэл хэсгүүд дээш өргөгдөх болон зарим эгэл хэсгүүд доош унах зэргээр тоосжилт үүсдэг.

Замын өргөн нь 4 м, 2 салаа гарна гэж үзвэл, нийт өргөн нь 8 м болно. Харин замаас хоёр тийш 50 м газарт автомашины хөдөлгөөнөөс үүдсэн тоосжилт тархах бөгөөд хөрс нь суларч идэвхтэй тоосжилт тархах нөхцлийг бүрдүүлсэн 108 м өргөн зурвас нь тус замын дагуух тоосжилтын эх үүсвэр болох ба нийт уртын дагууд 294840 м² талбайг тоос тархах боломжтой. Үүнийг 3 хэмжээст орчинд 2 метрийн өндөрт тархана гэвэл 589680м³ тоос агаарт тархана.

Дизелийн түлшнээс ялгарах хорт хий

Энэ үзүүлэлт нь технологийн автотээврийн түлшний зарцуулалт, хөдөлгүүрийн ажлын горимоос хамаарна. Дизель түлшээр ажиллах бульдозер, ачигч, автосамосвалууд, түлшний автоцистерн, ажилчдын автобус зэрэг механизмууд ашиглагдах ба судалгааны материалаас үзэхэд тэдгээрийн утааны яндангаар 1 тн дизелийн түлшний шаталтаас үүсэх хорт хий нь СО-0.1г, нүүрстөрөгч-0.03г, NO₂-0.04г, SO₂-0.02г, хөө-15.5кг, бензопирин-0.32г гэж тогтоожээ.

Тус үйл ажиллагаанаас ашиглалтын нийт жилд 25.6 тн дизель түлш зарцуулахад 396.8 кг хөө, 0.0082 кг бензопирин зэрэг хорт хий ялгарахаар байна.

Хүснэгт 10. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Нүүрс тээвэрлэх үеийн замаас босох тоос шороо нь агаарын тоосжилт ихэсгэнэ			x	
2	Нүүрс буулгах, ачих үеийн нүүрсний тоос			x	
3	Нүүрс түр хадгалах үед салхиар дамжин агаарын тоосжилт үүсгэнэ.		x		
4	Барилгын суурь шуудуу ухах, буцаан булах, шаардлагатай дэд бүтцийн бусад байгууламжуудыг барих, суурилуулах үед хөрс хуулалтаас үүдэлтэй газрын эвдрэл элэгдэл үүсч, тоос шороо агаарт дэгдэх, ойр орчмын агаар дахь тоосжилтын түвшинг ихэсгэх		x		
5	Үйл ажиллагааны явцад хүнд даацын машин механизмууд, авто машинуудаас ялгарч буй хорт утаа болон тоос шороо нь агаарын чанарт муугаар нөлөөлөх		x		
6	Дуу шуугиан	x			
	Нийт	1	3	2	
Нийт нөлөөллийн 16.7 % нь бага, 50 % нь Дунд, 33.3 % нь Их гэсэн үнэлгээтэй байгаа нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл Их гэж дүгнэж байна.					

3.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжих орчны хөрс нь байгалийн хүчин зүйлээс гадна тээврийн хэрэгслийн нөлөөгөөр олон салаа зам үүсч тэдгээрээс шалтгаалан үржил шим, унаган бүтцээ алдан салхинд хийсэх замаар элэгдэлд орсон байдал ажиглагдаж байна.

Хөрсөн бүрхэвчинд төслөөс дараах нөлөөллүүдийг үзүүлнэ.

Хүснэгт 11. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Тээврийн хэрэгслийн улмаас хөрс талхлагдах			x	
2	Барилга, байгууламжид өртөх	x			
3	Нүүрсний тоос, бүтэц алдагдсан үхмэл шороонд хөрсөн бүрхэвч дарагдах		x		
4	Техник машин механизмын түлш шатахуун, тос тосолгооны материал зэргийг алдаж асгаснаас хөрс бохирдох		x		
	Нөлөөллийн тоо	1	2	1	
Нийт нөлөөллийн 25 % нь бага, 50 % нь Дунд зэрэг 25 % нь Их гэсэн үнэлгээтэй байгаа нь хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл Дунд зэрэг байгааг харуулж байна.					

3.3. Төслөөс усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

Төсөл хэрэгжих талбайн ойр орчмын нутаг дэвсгэрт булаг, ил задгай урсац байхгүй. Тийм учраас төслийн хүрээнд хийгдэх барилгын ажил, нүүрс тээвэрлэлтийн үед гадаргын усны эх үүсвэрүүдэд үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй.

Хүснэгт 12. Усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Гадаргын түр зуурын урсацын байгалийн голдрилуудыг тээврийн хэрэгслийн замбараагүй хөдөлгөөний улмаас хаах эсвэл өөрчилсөн тохиолдолд тэдгээрээс тэжээгддэг энгийн гар худгууд болон ойр орчмын ургамлан бүрхэвчид нөлөөлөх.	x			
2	Төслийн хүрээнд барилга байгууламж барих зорилгоор газрын хэвлийг ухах, нүүрс		x		

	тээвэрлэх зэргээр улмаар байгалийн голдиролд өөрчлөлт оруулж болзошгүй.				
3	Төслийн барилга байгууламжуудын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх үед болон үйл ажиллагааны явцад ойр орчмын гадаргын түр урсацын голдрилуудыг ахуйн бохирдуулагчид, хог хаягдлаар бохирдуулах.	х			
	Нийт	2	1		
Нийт нөлөөллийн 75% нь бага, 25% нь дунд гэсэн ангилалд багтаж байгаа тул тус нөлөөлөх нөлөөллийн зэргийг БАГА зэрэг сөрөг гэж дүгнэж байна.					

3.4. Төслөөс ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Тоосжилт нь ургамалын фотосинтезийн процесст саад учруулж өсөлт хөгжлийг зогсоох.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан тэр орчмын газар талхлагдалд өртөж ургамлан нөмрөг устгах
- Барилга байгууламж барих, зэрэг ахуйн болон бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл хувьсаж өөрчлөгдөнө.

Төсөл хэрэгжих явцад ашиглалтын талбайд нийтдээ 10 га талбайг ашиглах бөгөөд тээвэрлэлтийн явц, тоосжилтоос ургамал талхлагдалд орох, ургамлын аймгийн зүйлийн бүрдэл цөөрч үгүй болох, өөрчлөгдөх зэргээр тухайн газарт экосистемийн өөрчлөлт гарах сөрөг нөлөөтэй.

Хүснэгт 13. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Барилга байгууламжийн улмаас ургамлан нөмрөгт нөлөөлөх		х		
2	Тоосжилт		х		
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс ургамалан нөмрөг талхлагдах			х	
4	Хатуу шингэн хог хаягдал	х			
	Нийт нөлөөллийн тоо	1	2	1	
Нийт нөлөөллийн 50% нь дунд, 25% нь бага, 25% нь их гэсэн ангилалд багтаж байгаа тул тус төслөөс тухайн нутгийн ургаман нөмрөгт нөлөөлөх нөлөөллийн зэргийг Дунд зэрэг гэж дүгнэж байна.					

3.5. Төсөл хэрэгжих орчны амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ

Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд:

Хүснэгт 14. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Машин техникийн дуу чимээ		х		
2	Техникийн осол аваар	х			
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн		х		
4	Хатуу, шингэн хог хаягдал	х			
	Нийт	2	2		
	Эзлэх хувь, %	50%	50%		
Нийт нөлөөллийн 50% нь Бага, 50% нь Дунд гэсэн ангилалд багтаж байгаа тул тус төслөөс тухайн нутгийн амьтны аймагт нөлөөлөх нөлөөллийн зэрэг бага болон дунд нөлөөлөлтэй гэж дүгнэж байна.					

3.6. Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд болон хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Тухайн төслөөс байгаль орчин болон нийгэм эдийн засаг, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, нүүрс ачиж буулгах үеийн тоосжилт зэрэг нь агаар орчин, хөрс, ургамлан нөмрөгт нөлөөлөх
- Орчны бохирдол /хөрс, агаар орчин/ хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Хүснэгт 15. Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Ажлын байр нэмэгдэх		х		
2	Хүн амын орлого нэмэгдэх		х		
3	Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх		х		
4	Тээврийн хэрэгслээс үүсэх тоосжилт, нүүрс ачиж буулгах үеийн тоосжилт хүн ам, жолооч нарын эрүүл мэндэд нөлөөлөх			х	
5	Тухайн орчны хөрсөн бүрхэвчид агуулагдах хүнд, хортой химийн элементүүд Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008 стандарт заасан үзүүлэлтүүдээс давсан тохиолдолд хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл			х	
6	Төслийн ажиллагсад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж, хууль эрх зүйн зүйл заалт мөрдөж ажиллаагүйгээс үүсэх, осол, эрсдэлийн нөлөөлөл			х	
	Нийт		3	3	
Нийт нөлөөллийн 50 хувь нь дунд зэрэг эерэг/, 50 хувь нь Их зэрэг сөрөг нөлөөтэй байна.					

3.7. Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Төслөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн үр дүнгүүдийг нэгтгэн доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 16. Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх болзошгүй нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
	Бага	Дунд	Их	Аюултай	
1. Байгаль орчин					
Газрын гадарга, хэвлий		1	1	0	
Газрын гадарга ба газар доорх ус	-2	-1	0	0	
Агаарын чанар	-1	-3	-2	0	
Хөрс	-1	-2	-1	0	
Ургамал	-2	-2	0	0	
Амьтан	-3	-1	0	0	
Нийт нөлөөллийн тоо	9	10	4	0	
Эзлэх хувь	39.1	43.4	17.3	0	
2. Нийгэм эдийн засгийн орчин					
Нутгийн оршин суугчид	0		+3	-3	0
Түүх соёлын дурсгал	0		0	0	0
Нийт нөлөөллийн тоо	0		3	3	0
Эзлэх хувь	0		50	50	0
Ерөнхий дүгнэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 39.1 хувь нь бага, 43.4 % нь дунд зэрэг, 17.3 % нь их зэрэг сөрөг нөлөөтэй байна. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 50 хувь нь дунд зэрэг сөрөг/, 50 хувь нь дунд зэрэг эерэг нөлөөтэй байна. Дээрх бүгдээс үзэхэд тус төсөл хэрэгжихэд байгаль орчинд болон нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл Дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.				

Тайлбар: - Сөрөг нөлөө
 + Эерэг нөлөө

“Гаалийн хяналтын талбай байгуулах” төслийн үнэлгээний дүнгүүдийг нэгтгэн дүгнэхэд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 50% нь бага, 37.5% нь дунд зэрэг, 12.5% нь их сөрөг нөлөөтэй байна. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 50% нь дунд зэрэг сөрөг, 50% нь дунд зэрэг эерэг нөлөөтэй байна.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан агуулга бүтэцтэй байна.

4.1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг үндэслэн боловсруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны (тухайн жилийн) байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон нэмэлт тодотгол үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

4.2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, батлах

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага (Байгаль орчин, аялал жуулчлалын яам) тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024 ОН)

Хүснэгт 17. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин						
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;		10 x 80.0 = 800.0	800.0	2024 он	- Агаарын тухай хууль - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд)
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр ажилчдыг хангах		50.0 * 19 хүн = 950.0	950.0	2024 он	- “Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага” MNS 5078: 2001 стандартын шаардлагыг хангасан байх.
	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгсэлээр хангаж хэрэгжүүлэх		20.0 * 9 хүн = 180.0	180.0	2024 оны 2 дугаар улиралд	- MNS ISO 226:2003 дуу чимээ-хэвийн норм- түвшний хэмжээ - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах. Уг багажийг БОШТЛ, “ОС МТ” ХХК зэргээс түрээслэх	Гаалийн хяналтын талбай 2 цэгт	30.0*4 120.0	30.0 төг х 2 удаа х 2 цэг жил = 120.0	2024 оны хавар 4-5 сар, намар 9-10 сар	
Усны нөөц, чанар						
Ус ашиглах	Зөөврийн ус	Гаалийн хяналтын талбай	--*--	--*--	Улирал бүр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль,

ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2024 ОН

	Ус ашигласны төлбөрийг төлөх, холбогдох ус ашиглах дүгнэлт, гэрээг байгуулах	Гаалийн хяналтын талбай	--*--	Тоолуурын заалтын дагуу	2024 он	- Усны тухай хууль
Хөрс, ургамлан бүрхэвч						
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Гаалийн хяналтын талбай	--*--	--*--	2024 он	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,
	Замыг хайрган хучилттай болгож тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	Гаалийн хяналтын талбай	1000,0	1000,0	2024 он	- MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Төслийн талбайн гадна, дотор талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх	Гаалийн хяналтын талбай	--*--	Үйл ажиллагааны зардлаар	2024 он	
	Хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх	Гаалийн хяналтын талбай		200,0	Сар бүр	
Тухайн жилийн зардлын дүн			3 250 000			

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2024 ОН)

Хүснэгт 18. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Мод тарих /хайлаас, буйлс, улиас/	Гадаад тээвэрлэлтийн зам дагуу 500 уртааш метр газар	Ширхэг	200	1 суулгацын дундаж үнэ 8000 төгрөг**	1600,0	2024 он	- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008 - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл.
		Нийт					1600,0		

** huree.mn/модны-суулгацын-үнэ-ханш-2023/

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих орчны түүх, соёлын өв дурсгалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2024 ОН)

Хүснэгт 19. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Гаалийн хяналтын талбай	-	--*--	Өдөр тогтмол бүр,	- Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1, - Галын аюулгүй байдлын тухай хууль
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад		500,0	2024 онд 1 удаа	- MNS 4244:1994 Хөдөлмөр хамгаалалын систем Галын аюулгүй байдал Ерөнхий шаардлага
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Гаалийн хяналтын талбай		500,0		- MNS 5566:2005. Аж ахуй нэгж, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Бүх ажилчдад		200,0		
Нийт дүн				1200,0		

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2024ОН)

Төслийн үйл ажиллагаанаас дараах хатуу хог хаягдал гарна. Үүнд:

- 1) Энгийн хог хаягдал-Энгийн хог хаягдлын дийлэнх хувийг ахуйн хог хаягдал бүрдүүлнэ. Ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хаягдлууд болох хоол хүнсний үлдэгдэл, материалын сав баглаа боодол цаас, пластмасс, төмөр, шил, яс, мод
- 2) Аюултай хог хаягдал-Гаалийн хяналтын талбайгаас Засгийн газрын 2018 оны 116 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Аюултай хог хаягдлын жагсаалт”-д заасан аюулын зэрэглэлээр шууд аюултай хог хаягдал гэж үзэх. Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх тосны шүүр, тоормосны шингэн, хар тугалгатай батарей, аккумуляторын хаягдал үүсч болозошгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалын хавсралтын хүрээнд Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтын 3,8,9 заасан хог хаягдал гарахаар байна.

Хүснэгт 20. Аюултай хог хаягдлын ангилалын жагсаалт

Хог хаягдлын эх үүсвэрийн бүлэг	Хог хаягдлын эх үүсвэрийн дэд бүлэг, бүлгийн код	Хог хаягдлын код	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын зэрэглэл
16.Бусад хог хаягдал. (Аль ч салбарт хамаарагдах эх үүсвэрээс үүсэх боломжтой хаягдлууд орно)	16 01. Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал	16 01 02*	Ашиглалтаас гарсан автомашин	Х
		16 01 04*	Тосны шүүр	А
		16 01 05*	Мөнгөн ус агуулсан эд анги	Х
		16 01 06*	Полихлорт бифенил (PCBs) агуулсан хуванцар, нийлэг эд ангийн хаягдал	Х
		16 01 07*	Тэсрэмтгий шинж чанартай эд ангийн хаягдал (хамгаалалтын дэр г.м)	А
		16 01 08*	Асбест бүхий тоормосны жийргэвч (накладка)	Х
		16 01 10*	Тоормосны шингэн	А
		16 01 11*	Хортой нэгдэл агуулсан антифризийн (хөлддөггүй) шингэний хаягдал	Х
	16 03. Гологдол болон ашиглагдаагүй бүтээгдэхүүн (хүнсний бүтээгдэхүүн хамаарна)	16 01 18*	16 01 04 -16 01 08 болон 16 01 10, 16 01 11-д зааснаас бусад хортой эд анги	Х
		16 03 01*	Хортой бодис агуулсан органик бус хаягдал	Х
	16 06. Батарей, аккумулятор	16 03 03*	Хортой бодис агуулсан органик хаягдал	Х
		16 06 01*	Хартугалгатай батарей, аккумуляторын хаягдал	А
		16 06 02*	Никель-кадмийн батарейн хаягдал	А
		16 06 03*	Мөнгөн ус агуулсан батарейн хаягдал	А
	16 12. Мал, амьтны сэг зэм	16 06 06*	Батарей, аккумуляториас ялгаж авсан электролитийн уусмал	А
		16 12 02*	Халдварт өвчин, хордлогын улмаас үхсэн болон зориудаар устгасан мал, амьтны сэг зэм	А

Эх үүсвэр (ЗГ-ын 2018 оны 116 дүгээр тогтоолын хавсралт “Аюултай хог хаягдлын жагсаалт”-аас)

Тайлбар :

- Аюултай хог хаягдлыг “А”, хяналттай хог хаягдлыг “Х” гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэнэ.
- “А” гэсэн тэмдэглэгээтэй хог хаягдлыг шууд аюултай хог хаягдал гэж үзнэ.
- “Х” гэсэн тэмдэглэгээтэй хог хаягдлыг аюултай хог хаягдалд хамруулах эсэхийг шинжилгээгээр тогтоох ба аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшинтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээгээр агуулж байвал “аюултай” гэж үзнэ.
- Аюултай болон хяналттай хог хаягдлын код нь “*” гэсэн тэмдэглэгээтэй байна.

Хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ

Энгийн хог хаягдал - Төсөл хэрэгжүүлэгчид энгийн хог хаягдлыг дараах байдлаар зайлуулах, мөрдөж ажиллах зөвлөмжийг санал болгож байна.

1) “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” -ын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах шаардлагатай.

2) Дараах шаардлагыг хангасан хогийн савтай болох шаардлагатай. Үүнд:

- Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;
- Галд тэсвэртэй материалаар хийгдсэн;
- Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байх

3) Ханбогд сумын хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, эсвэл сум орон нутгаас зөвшөөрсөн хогийн цэгт хаях

4) Бусад:

- Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;
- Хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;
- Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
- Хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;

Аюултай хог хаягдлыг зайлуулах

- Төсөл хэрэгжүүлэгч нь Аюултай хог хаягдлыг 180 хоног хүртэл хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно.
- Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална. Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэх.
- Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
- Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд

хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;

Шингэн хог хаягдал

Гаалийн хяналтын талбайн ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх шингэн хог хаягдал гарна. Төслийн үйл ажиллагааны ахуйн бохир шингэн хаягдал 1 хоногт 0.18 м^3 ($0,18 \text{ м}^3$ ус хэрэглэх ба үүний 70% -ийг шингэн хаягдал болно гэж үзэв) $0,12\%$ нь шингэн хаягдал болно. Шингэн хаягдлыг хөрсөнд нэвчихээр цооногийг хийх. Тус төслийн хүрээнд стандартын дагуу нүхэн жорлонг ашиглах шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаанаас гарах шингэн хог хаягдлыг бохирын цооног байгуулж зайлуулахаар төлөвлөсөн байна.

ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2024 ОН

Хүснэгт 21. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн Өртөг /мян.төг/	Зардал, мян.төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгаж байх	Гаалийн хяналтын талбай		500,0	2024 он	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	Ажилчдын байр болон бусад газар	120,0х5ш=600,0	600,0		
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Гаалийн хяналтын талбай засварын газар		Мэргэжлийн байгууллагын гэрээний дагуу тооцох	2024 он	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Гаалийн хяналтын талбай	-	500,0	2024 он	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Эко нойл болон саарал усыг хөрсөнд нэвчүүлэх технологи ашиглах		ҮА-ны зардалд			
Нийт зардал			600,0	1600,0		

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутагт хэрэгжих “Гаалийн хяналтын талбай байгуулах” төслийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгав.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны бүрдэл хэсгүүдийг тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана.

Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Нэг. Агаарын чанарын хяналт шинжилгээ						
1.1	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO,) шинжилгээ хийлгэх Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Гаалийн хяналтын талбай байгуулах үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Талбайн гадна автозамын дэргэд, авто пүү, ажилчдын байрны дэргэд тус тус цэг сонгох	Улирал тутамд 1цэгт	46.0 х 4 удаа= 184.0х2=368,0 ¹ /Нэг удаагийн хэмжилтээр 2 ажиглалтыг зэрэг хийх/	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Хүнд даацын машины тээврийн зам, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим 2 цэгт	Хавар, намар (2 удаа)	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 50.0 х 2 удаа= 200.0	
Хоёр. Усны хяналт шинжилгээ						
2.1	Зөөврийн ус	Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Ус авдаг газраас	Улирал тутамд (4 удаа)	Усны ерөнхий хими 46.0 х 4 = 184.0 ²	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт

¹ ЦУОШГ-ын Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторийн үнээр тооцов.

² ШУА-ын Газарзүй-геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лабораторийн үнээр тооцов.

						MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Хөрсний хяналт шинжилгээ						
3.1	Хөрсний агрохими (хими, физик шинж чанар) Хүнд металлууд (Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), зэс (Cu), хүнцэл (As), молевден (Mo), стронций (Sr), ванадий (V) тодорхойлуулах	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган төрх хэлбэр өөрчлөгдөх, шатах тослох материалаар бохирдох	Талбайн гадна, хатуу хог хаягдлын талбайн ойр тус бүр 1 цэг сонгох, нүүрсний авто пүүний хажууд 1 цэг	Жилд 2 удаа	Хөрсний химийн шинжилгээ 30,0 х 3=90,0 ³ Хүнд металл шинжилгээ 50х3=150,0 ⁴	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ургамлын аймаг						
4.1	Ургамал устах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биомасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Гаалийн хяналтын талбай болон түүний ойр орчим	Жилд 1 удаа	1000.0	Мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 5 ЖИЛИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					1 992,000	

³ ШУА-ын Газарзүй-геоэкологийн хүрээлэн, хөрсний шинжилгээний лабораторийн үнээр тооцов.

⁴ “Эс Жи Эс” ХХК-ийн лабораторийн үнээр тооцов.

АРВАННЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүснэгт 23. Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага
зохион байгуулалт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			сар	сар	сар		
1	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	Осол эрсдэлийн менежментийн зардалд тусгасан		6		ХАБЭАБО ажилтанууд	
2	Ажиллагсдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	3,000,000			8	Захирал	УБ-т нарийн мэргэжлийн эмнэлэг, эрүүл мэндийн үзлэгт хамруулах
	Нийт	3,000,000					

АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД
ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024 ОН)

Хүснэгт 24. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах хуваарь

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах газар
БОАЖЯ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг боловсруулж БОАЖЯ-нд хүргүүлнэ.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, гүйцэтгэл	2024 оны 11 дүгээр сарын 20-ний дотор		БОАЖЯ
Өмнөговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг хүргүүлж, санал авах	Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайлан	2024 оны 11 дүгээр сарын 01-ний дотор		
Ханбогд сумын Жавхлант багийн иргэд	Иргэдэд энэхүү төслийн тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах	-Төслийн танилцуулга - Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ - Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт	2024 оны 9-10 дугаар сар	500,000	Ханбогд сумын Жавхлант багийн иргэдийн хурлын танхим
Нийт				500,000	

Хүснэгт 25.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Зардлын төрөл	Тухайн жилийн зардал, мян.төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	7650,0
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3250,0
	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1600,0
	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1200,0
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1600,0
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1992,0
	Агаарын чанар	568,0
	Усны чанар	184,0
	Хөрсөн бүрхэвч	240,0
	Ургамал	1000,0
3	Удирдлага зохион байгуулалт	3000,0
4	Төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах	500,0
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		13142,0